

**АРХАНГАЙ АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ,
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2020 ОНЫ
6 ДУГААР САРЫН АЖЛЫН МЭДЭЭ**

Нэг. Удирдлага, зохион байгуулалтын талаар

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын үйл ажиллагааны мэдээлэл

2020 оны 6-р сарын 2, 3-ны өдрүүдэд Монгол Улсын Засгийн газар, НҮБ-ын хөгжлийн хөтөлбөрөөс зохион байгуулсан “Орон нутгийн хөгжлийн бодлого боловсруулах, хэрэгжүүлэхэд системийн шинжилгээний аргачлалыг ашиглах нь” сэдвийн хүрээнд Архангай аймгийн “Тогтвортой аялал, жуулчлал”, “Байгаль орчин-хөрсний бохирдол” сэдвүүдээр сургалт хийж, хэлэлцүүлэг өрнүүлж загварчлал боловсрууллаа.

Аймаг, сумдын ИТХ-ын хуралдаан хийсэн тоо 38, ирцийн дундаж 85,5 хувьтай, шийдвэрлэсэн асуудлын тоо 386 байгаа бол, Тэргүүлэгчдийн хуралдаан 217 удаа хуралдсан, 75.4 хувийн ирцтэй, 702 тогтоол гаргасан байна.

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хуралдаан 6 удаа хуралдаж, хуралдаанаар нийт 33 асуудлыг хэлэлцэж тогтоол гаргалаа. Хуралдааны материалыг 1-ээс доошгүй хоногийн өмнө Тэргүүлэгчдэд хүргэж, шаардлагатай мэдээллээр хангасан. Хуралдааны дундаж ирц 74.6 хувьтай байв.

Сонгуулийн ерөнхий хорооноос ирүүлсэн албан бичгийн дагуу 2016 оны УИХ, орон нутгийн сонгуулийн саналыг хуудсыг устгах ажлын хэсгийг байгуулж аймгийн архивт хадгалагдаж байгаа хадгалах хугацаа дууссан УИХ-ын сонгуулийн саналын хуудас 19 сумын 104 хэсгийн битүүмжлэл бүхий 88278 хуудас, орон нутгийн хурлын сонгуулийн 19 сумын 232 хадгаламжийн нэгж бүхий устгах бичгийн жагсаалтыг үйлдэж, устгал хийх ажлыг 2020 оны 6-р сарын 10-ны өдөр зохион байгууллаа.

2020 оны эхний хагас жилд цагаатгалын нөхөх олговор авах хүмүүст 40.0-80.0 сая төгрөг олгох ажлыг 3 удаа зохион байгуулав. Эрдэнэмандал сумын өндөр настан Ш.Бямбасүрэн, Ш.Лхагвадулам нарт тус бүр 20.0 сая төгрөг, Эрдэнэбулган сумын 4-р багийн иргэн Гэлэгжамцын Магсаржавт 40,000,000 төгрөг олгож, Төвшрүүлэх сумын 2-р багийн иргэн Довдоннямын Надалын 40,000,000 төгрөгийн шийдвэр санхүүжилт ирээгүй хүлээгдэж байна.

Аймгийн Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааны мэдээлэл

Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоол, аймгийн Засаг даргын 2017 оны 278, 2020 оны 254 дүгээр захирамжуудаар баталсан журмуудад заасны дагуу агентлаг, сумын ЗДТГ-ын 2020 оны эхний хагас жилийн үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээг хийж байна.

Засгийн газрын 2019 оны 4-р сарын 17-ны өдрийн 149 дүгээр тогтоолоор “Нэг цонхны үйлчилгээ”-г “Төрийн үйлчилгээний нэгдсэн төв” болгосонтой холбоотойгоор сум бүр оператортой болж иргэн, хуулийн этгээд төрийн 54 төрлийн үйлчилгээг сумаасаа авах бүрэн боломжтой болсон. Тус ажлын хүрээнд аймгийн Засаг даргын Тамгын газрын мэргэжилтэн, төрийн үйлчилгээний нэгдсэн төвийн менежер, хяналтын ажилтнууд зарим сумдын опертаторуудын үйл ажиллагаатай танилцаж, арга зүйн зөвлөгөө өгч, мөн энэ үеэр “Төрийн үйлчилгээний нэгдсэн төв”-ийн үйл ажиллагааг сум орон нутгийн иргэдэд танилцуулсан байна.

“Төрийн үйлчилгээний нэгдсэн төв”-ийн үйл ажиллагааг 5-р сарын 13-ны өдрөөс эхлэн аймгийн 19 суманд эхлүүлсэн бөгөөд 6-р сарын 17-ны байдлаар аймгийн хэмжээнд нийт 211 иргэн, хуулийн этгээд лавлагаа авсан байна.

Улсын Их Хурлын гишүүний дэмжлэгээр, улсын төсвийн 240.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар 2020-2021 онд хэрэгжих Булган, Ихтамир, Өндөр-Улаан, Чулуут, Тариат, Хангай, Цахир, Жаргалант сумдын ЗДТГ, Ерөнхий боловсролын болон бага сургууль, Хүүхдийн цэцэрлэгийг шаардлагатай компьютер, техник, тоног төхөөрөмжөөр хангах ажлын хүрээнд 2020 онд 114.0 сая төгрөгийн өртөг бүхий суурин компьютер, проектор, дэлгэц, өнгөт болон хар принтер, ламинатор, зурагт, зөөврийн чанга яригч, өсгөгч, химийн татах шүүгээ, зургийн аппарат, гүйлтийн зам, бөхийн дэвжээ зэрэг 13 нэр төрлийн буюу техник, тоног төхөөрөмжийг дээрх сумдын 12 сургууль, 8 цэцэрлэгт

хүлээлгэн өгсөн байна. 2021 оны 1-р улиралд багтаан 2 дахь ээлжийн компьютер, техник тоног төхөөрөмжийг олгох юм.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Чулуут, Өндөр-Улаан, Ихтамир, Хангай, Цахир, Булган сумдын Эрүүл мэндийн төвүүдэд шинээр мобайл технологийг нэвтрүүлээ. Мобайл технологийг сумдад нэвтрүүлснээр иргэд хурдавчилсан оношлуур, хэрэгсэл ашиглан эрүүл мэндийн цогц тусламж үйлчилгээг гэртээ буюу явуулын хэлбэрээр авах боломж бүрдэж байгаа юм.

Улсын Их Хурлын ээлжит сонгуулийг аймгийн Сонгуулийн хороо, 105 хэсгийн хороод хууль, журмын дагуу 6-р сарын 24-ний өдрийн 07.00-22.00 цагт амжилттай зохион байгууллаа.

Улсын Их Хурлын сонгуулийн үйл ажиллагаа болохтой холбогдуулан аймгийн Засаг даргын 2020 оны 6-р сарын 22-ны өдрийн а/396 дугаар захирамжаар 6-р сарын 23, 24-ний өдрүүдэд аймгийн хэмжээнд архи, согтууруулах ундаагаар үйлчлэх, худалдахыг хориглож, биелэлтэд холбогдох газрууд хяналт тавьж ажилласан.

Засгийн газрын 2020 оны 5-р сарын 27-ны өдрийн 188 дугаар тогтоол, Сонгуулийн ерөнхий хорооны 2020 оны 6-р сарын 10-ны өдрийн 2/191 дүгээр “Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажиллах тухай” албан бичгийн дагуу сонгуулийн 105 хэсгийн хорооны санал авах байранд сонгогчдын халууныг хэмжих, эрүүл мэндийн байдлыг тандах арга хэмжээг зохион байгуулж, эрүүл мэндийн байгууллагын 142 ажилтан ажилласан байна.

Мөн сонгуулийн санал өгөх байруудад урьдчилан сэргийлэх халдваргүйжүүлэлт хийх зөвлөмжийг боловсруулж, аймгийн Сонгуулийн хороонд хүргүүлж, Зоонозын өвчин судлалын төв, сумын Эрүүл мэндийн төвүүд нийт 61 санал авах байрны 17844 м.кв талбайд халдваргүйтгэл хийсэн.

Архангай аймагт бие даан нэр дэвшсэн Р.Бадмаанямбуугийн гомдлын дагуу аймгийн 105 хэсгийн хорооноос хяналтын тооллого хийгдээгүй 57 хэсгийн хорооноос сугалаагаар сонгогдсон Өлзийт сумын Ямаат баг 38-р хэсгийн хороо, Батцэнгэл сумын Дайр бор баг 17-р хэсгийн хороо, Өндөр-Улаан сумын Азарга баг 42-р хэсгийн хороо, Эрдэнэбулган сумын 2 дугаар баг 3-р хэсгийн хороо, Хотонт сумын Орхон баг 78-р хэсгийн хороо гэсэн 5 хэсгийн хороонд тухайн сумдын сонгуулийн хорооны дарга, нарийн бичгийн дарга, хэсгийн хороодын дарга, гишүүд, 18 ажиглагч оролцож хяналтын тооллогыг зохион байгуулсан байна. Хяналтын тооллогын дүн санал тоолох төхөөрөмжийн дүнтэй таарсан байна.

Мал, малын гаралтай түүхий эд бүтээгдэхүүний гарал үүслийг тодорхойлох “Мөшгөх тогтолцооны систем”-ийг орон нутагт хэрэгжүүлэх зорилгоор Хөдөө аж ахуйн тасаг, мал үржүүлэг технологийн ажил үйлчилгээний болон мал эмнэлгийн үйлчилгээний нэгжүүдийн үйл ажиллагааг дэмжиж орон нутгийн төсвөөс 100.0 сая төгрөг зарцуулан Notebook 13 ширхэг, Tablet 53 ширхэг, 80 мм хэвлэгч 53 ширхгийг, улсын төсвийн хөрөнгөөр 20.3 сая төгрөгийн үнэ бүхий компьютер 5 ширхэг, ээмэгний код уншигч 5 ширхэг, 80мм хэвлэгч 5 ширхгийг хөдөө аж ахуйн тасаг, мал үржүүлэг технологийн ажил үйлчилгээний болон мал эмнэлгийн үйлчилгээний нэгжүүдэд олголоо.

Хоёр. Эдийн засаг, төсөв, санхүүгийн бодлогын хүрээнд

Татвар төлөлт

6-р сард улсын төсөвт 105690.0 мянган төгрөг, орон нутгийн төсөвт 958111.6 мянган төгрөг төвлөрүүлэхээс улсын төсөвт 105690.0 мянган төгрөг, орон нутгийн төсөвт 958111.6 мянган төгрөгийг төвлөрүүлэхээр ажиллаж байна

Цахим төлбөрийн баримтын систем ашиглан татвараа төлөх талаар аймгийн Татварын хэлтсийн цахим хуудсанд мэдээ, мэдээллийг байршуулан 176 татвар төлөгчийн бүртгэлтэй хаягаар илгээлээ.

Нэмэгдсэн өртгийн албан татварын нэгдсэн системд зах худалдааны төвүүдэд үйл ажиллагаа явуулж байгаа 386 түрээслэгч иргэдийг холбуулахаар холбогдох судалгааг гарган Татварын ерөнхий газарт хүргүүлээ.

Татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд бүртгэлтэй галт зэвсгийн албан татвар төлөгч 170, үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар төлөгч 16 иргэний хөрөнгийн ногдлын өөрчлөлтийг бүртгэлээ.

Хөрөнгө оруулалт

2020 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар нийт 49.076.3 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 63 төсөл арга хэмжээ хэрэгжихээр төлөвлөгдсөн. Үүнээс оны эхний 5 сарын байдлаар 2.011.7 сая төгрөгийн гүйцэтгэлтэй байна.

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар нийт 4.133.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 50 төсөл арга хэмжээ хэрэгжинэ.

Үүнээс, авто замын сангийн хөрөнгөөр 435.0 сая төгрөгийн 9 төсөл, арга хэмжээнээс 9 сая төгрөгийн, аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 3.565.3 сая төгрөгийн 25 төсөл, арга хэмжээ хэрэгжихээс 79.0 сая төгрөгийн гүйцэтгэлтэй байна.

Орон нутгийн төсвийн хөрөнгөөр 132.7 сая төгрөгийн 3, байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний 427.2 сая төгрөгийн зардлаар 13 төсөл арга хэмжээ хэрэгжихээр батлагдсан байна.

Орон нутгийн өмч, худалдан авах ажиллагаа

Улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх “Өгийнуур-Батцэнгэл-Ихтамир чиглэлийн 63 км хатуу хучилттай авто зам, төмөр бетон гүүрийн байгууламжийн барилга угсралтын ажил, 2019-2021 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих ажилд техник технологийн хяналт хийх ажлыг гүйцэтгэх 923.2 сая төгрөгийн өртөг бүхий зөвлөх үйлчилгээ, сумын төвийн дахин төлөвлөлтийн ажлын зураг төсөв /Архангай, Ихтамир сум/ зөвлөх үйлчилгээний зөвлөх үйлчилгээ үзүүлэх хүсэлтэй этгээдийг мэдүүлгээ ирүүлэх тухай тендерийг дахин зарласан үнэлгээний шатандаа явж байна.

6-р сард орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжих Ихтамир сумын Ахмадын өргөө, Мал эмнэлгийн барилгын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах 50.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй тендер зарлаж, 4 тэрбум 407.9 сая төгрөгний төсөл арга хэмжээний тендерийн гэрээ байгуулсан байна.

Санхүүгийн хяналт

Өгийнуур, Өлзийт, Батцэнгэл сумдын төсөвт албан байгууллагуудад хийсэн аудит, хяналт шалгалтын дүнгээр нийт 18 төсвийн байгууллагыг хамруулж, улсын байцаагчийн 15 актаар 13.9 сая төгрөгийн нөхөн төлбөр тогтоож, аймаг орон нутгийн төсвийн орлогын дансанд төвлөрүүлэх, 2 байгууллагад 390.0 мянган төгрөгийн зөрчлийг арилгуулах хугацаатай албан шаардлага хүргүүлсэн.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд аймгийн Засаг даргатай 2020 онд байгуулсан гэрээнд тусгагдсаны дагуу аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газар, Мал эмнэлгийн газрын 2018-2019 оны үйл ажиллагаанд аудит, хяналт шалгалт хийгдэж, тайлагнах шатандаа явж байна.

Гурав. Хууль, эрх зүйн бодлогын хүрээнд Хууль, хяналт

6-р сард тус аймагт 8 удаагийн аюулт үзэгдэл, техникийн холбогдолтой осол тохиолдосноос объектын гал түймэр 6, мал, амьтны гоц халдварт өвчин 2 удаа тус тус тохиолдож 4 гэр шатаж иргэдийн хувийн өмчид нийт 43.2 сая төгрөгийн хохирол учирсан байна.

ОБГ-ын Гал түймэр унтраах аврах 51 дүгээр ангийн алба хаагчид объектын гал түймэр 3 удаагийн дуудлаганд ажиллаж 1 өвөл зуны сууц иргэдийн 50 гаруй сая төгрөгийн өмч хөрөнгийг гал түймрийн аюулаас авран хамгаалсан байна.

Засгийн газрын 2020 оны 5-р сарын 27-ны өдрийн 188 дугаар тогтоол, Онцгой байдлын ерөнхий газрын даргын баталсан удирдамжийн дагуу Улсын Их Хурлын ээлжит сонгууль болохтой холбогдуулан аймгийн Сонгуулийн хороо, санал авах байр болон нам, эвсэл, бие даан нэр дэвшигчдийн ухуулах, сурталчилгааны барилга байгууламжуудад хамгаалах болон гал түймрийн улсын хяналтыг хэрэгжүүлэх төлөвлөгөөт хяналт шалгалтаар аймгийн Сонгуулийн хороо, Эрдэнэбулган сумын санал авах байр-11, нам, эвсэл, бие даан нэр дэвшигчдийн ухуулга, сурталчилгааны гэр, барилга байгууламжууд-

Эд хөрөнгийн эрхийн бүртгэл

2020 ий 6-р сарын 26-ны өдөр 364 үйлчилгээг
өргөжүүлж аажим аажим эргүүлж өгөхөөр үйлчилгээг

- Газар өмчлөх эрхийн анхны бүртгэл – 19
- Үл хөдлөх хөрөнгө өмчлөх эрхийн анхны бүртгэл - 13
- Шинээр бүртгүүлсэн орон сууцны бүртгэл – 5
- Газар эзэмших эрхийн анхны бүртгэл – 45
- Арилжааны гэрээ – 0
- Худалдах худалдан авах гэрээ – 49
- Бэлэглэлийн гэрээ – 10
- Барьцааны эрхийн бүртгэл – 240
- Өв залгамжлал – 5
- Хамтран өмчлөгч өөрчлөгдөх – 3
- Лавлагаа – 2
- Бусад эрхийн бүртгэл – 7

Хорвоо бүлэглэлийн өмчлөх эрхийн бүртгэл 41 өмчлөгчөөр
Дээрх бүртгэлүүдийг хийж улсын төсөвт үйлчилгээний хөлс 3.368.870 тэмдэгтийн
хураамжид 148.757 төгрөг, үл хөдлөх хөрөнгө худалдсанаас оруулсан татварын орлого
9.993.760 төгрөг төвлөрүүлсэн байна.

Хуулийн этгээд

- Шинээр бүртгүүлсэн – 8
- Өөрчлөлт – 10
- Тамганы хяналтын дугаар олгосон – 10 бүртгэл хийсэн.

Дөрөв. Боловсрол, соёл, эрүүл мэнд, нийгмийн хамгааллын бодлогын хүрээнд Боловсрол

2019-2020 оны хичээлийн жилд танхимын болон дүйцсэн хөтөлбөрөөр суралцаж
төгссөн төгсөгчдөд суурь боловсролын 1255, бүрэн дунд боловсролын 1065 гэрчилгээг
олгосон байна.

7-р сарын 2-ноос 5-ны өдрүүдэд элсэлтийн ерөнхий шалгалтыг Эрдэнэбулган
сумын 1, 3, 4-р сургуулиуд дээр зохион байгуулахтай холбогдуулан шалгалт авах байр,
ажиллах зохион байгуулагч, хянагч багш нарын бэлтгэх зохион байгуулалтын арга
хэмжээг авч ажиллаж байна.

Нийт 974 сурагч ЭЕШ-д орохоор бүртгүүлж давхардсан тоогоор 10 хичээлийн 2916
шалгалт өгөхөөр байна.

Соёл, урлаг

Хорио цээрийн дэглэм тогтоож, олон нийтийг хамарсан үйл ажиллагаа, үзвэр
үйлчилгээг зохион байгуулахыг хориглосонтой холбогдуулан аймгийн Нийтийн номын
сан, Хөгжимт драмын театр, Музей иргэд олон нийтэд чиглэсэн урлаг, соёлын үйлчилгээг
цахимаар болон зайнаас зохион байгуулж байна. Тухайлбал:

Нийтийн номын сан үндсэн фонд, нийтийн болон хүүхдийн уншлагын танхимаар
нийт 9 уншигч шинээр бүртгэж, 47 ирэгсэдэд 379 ном, сонин олгож, зөөврийн номын
сангийн үйлчилгээгээр төрийн 14 байгууллагын 85 ирэгсэдэд 174 номоор тус тус
үйлчилсэн.

Аймгийн Музей “Заяын хүрээний үүсэл, хөгжил”, Зая гэгээн Жамбацэрэнгийн
хэрэглэж байсан “Таван саваагүй”, “Хэт хутга”, “Толгойн боолт”, “Хаш таваг”, “Шанаган
хуур”, “Домбо”, “Дэвэр” “Ганлин”, “Уйгурын үеийн хувцас”, “Хүрэл шанага” зэрэг
үзмэрүүдийн мэдээллийг байгууллагын фэйсбүүк хуудас болон “Монцамэ агентлаг”,
“Архангай амьдрал сонин”, “Архангай сэтгүүл” зэрэг мэдээллийн эх үүсвэрээр дамжуулан
олон нийтэд хүргэж байна.

Хөгжимт драмын театр орон нутгийн “АВ” телевизтэй хамтран шинэ уран бүтээлийн тоглолтын видео бичлэгийн зураг авалтыг 5 өдрийн турш зохион байгуулсан.

Эрүүл мэнд

6-р сарын 9-ний өдөр “Нярайн эрт үеийн нэн шаардлагатай тусламж”, “Хүүхдийн өвчний цогц менежмент”, “Хүчилтөрөгч өтгөрүүлэгчийн хэрэглээ, цэвэрлэгээ” сэдвүүдээр сумдын эмч, мэргэжилтнүүдэд цахим хэлбэрээр сургалт зохион байгуулж 12 сумын 108 эмч, мэргэжилтэн хамруулсан байна.

Тусгай зөвшөөрлийн гэрчилгээ сунгуулах 15, шинээр тусгай зөвшөөрөл авах 1, нийт 16 эрүүл мэндийн байгууллагын хүсэлтийг хүлээн авч ажлын албаны хурлаар хэлэлцүүлсэн.

Амны хаалтыг олон нийтийн газар, гудамж талбайгаар явахдаа болон худалдаа, үйлчилгээний байгууллагаар үйлчлүүлэхдээ бүх иргэд зүүх, мөн үйлчилгээний байгууллагын бүх ажилчид амны хаалт зүүх шаардлагыг хэрэгжүүлэхэд хяналт тавих, хариуцлага тооцох эрх бүхийн байгууллага, албан тушаалтанд үүрэг чиглэл өгч, идэвхжүүлж ажиллах хүсэлтийг аймгийн Онцгой комиссын шуурхай штабын даргад хүргүүлсэн.

“Пипл Ин Нийд” олон улсын ТББ-тай хамтран “Цэвэр гар” арга хэмжээг зохион байгуулж, аймгийн төвийн хөгжлийн бэрхшээлтэй болон эмзэг бүлгийн 350 хүүхдэд хүнс, эрүүл ахуйн тусламжийн багцыг тараасан.

“Коронавируст халдварын үеийн удирдлага, зохион байгуулалт, халдварын сэргийлэлт хяналт, эмнэлзүйн сургагч багш бэлтгэх сургалт”-ыг 6-р сарын 11, 12-ны өдрүүдэд ЭМЯ, ХӨСҮТ, АШУҮИС-ын сургагч багш нартай хамтра зохион байгуулж ЭМГ, Нэгдсэн эмнэлгээс нийт 20 сургагч багшийг бэлтгэсэн.

Нэгдсэн эмнэлэг, бүх хувийн хэвшлийн бүх эмнэлэг, бүх өрхийн эрүүл мэндийн төвүүдийн нийт 390 эмч, эмнэлгийн ажилтнуудад “Коронавируст халдварын үеийн удирдлага, зохион байгуулалт, халдварын сэргийлэлт хяналт, эмнэлзүйн менежмент” сургалтыг хийж, мэдлэгийг дээшлүүлэв.

“Коронавируст халдварын үеийн халдварын сэргийлэлт, хяналт, албан хаагчдыг халдвараас хамгаалах” сургалтанд Цагдаагийн газар, Онцгой байдлын газар, Мал эмнэлгийн газар, Мэргэжлийн хяналтын газар, Шүүхийн шинжилгээний алба, Авто тээврийн төв, ЭБСумын ЗДТГ-ын нийт 22 ажилтныг хамруулж, мэдлэгийг дээшлүүллээ.

Хөдөлмөр эрхлэлт, нийгмийн хамгаалал

2020 оны 6-р сарын байдлаар Хөдөлмөрийн зах зээлийн нэгдсэн сан LMIS программд ажил идэвхитэй хайгч 994 иргэн бүртгэлтэй байгаагаас 477 эмэгтэй. Шинэ ажлын байр 423 үүнээс байнгын ажлын байр 260, улирлын ажлын байр 29, түр ажлын байр 134 байна. Ажил олгогч байгууллагуудаас ирүүлсэн ажлын байрны захиалга 384, зуучлал 376 байна. Тухайн сарын 18-ны байдлаар 96 иргэн нь шинээр бүртгүүлж, LMIS программд шивж оруулсан. Ажил идэвхитэй хайгч иргэдийг боловсролын түвшингээр ангилвал: боловсролгүй- 10, бага- 32, суурь-284, бүрэн дунд- 472, техникийн болон мэргэжлийн анхан шатны – 28, тусгай мэргэжлийн дунд-19, Дипломын бакалаврын-149 иргэнийг тус тус бүртгэж мэдээллийн бааз үүсгэн ажилласан байна. Тухайн сард ажилгүйдлийн тэтгэмж авахаар ирсэн 13 иргэнийг LMIS програмд шивж оруулан тодорхойлолт гарган өгч НДХэлтэс рүү хүргүүлсэн.

Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн сэргээн засах үйлчилгээг гэрээлэн гүйцэтгэх Магадлан итгэмжлэгдсэн “Очцо” эрүүл мэндийн төв, “Хангай манба дацан” зэрэг аж , ахуй нэгжтэй гэрээ байгуулан ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, өрх толгойлсон эх /эцэг/ зэрэг зорилтот бүлгийн иргэдийг хамруулан ажиллаж байна.

Нийгмийн даатгалын санд 2020 оны 6-р сарын 25-ны байдлаар нийт 8.2 тэрбум төгрөгийн шимтгэлийн орлого төвлөрүүлж, орлогын төлөвлөгөөг 107.8 хувиар биелүүлсэн байна. Давхардсан тоогоор 15.2 мянган иргэний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн зардалд нийт 25.7 тэрбум төгрөг зарцуулжээ. Улсын төсвөөс 1995 оноос өмнө

тэтгэвэр тогтоолгосон иргэдийн болон цэргийн тэтгэвэрт 3020.3 сая төгрөгийг нийгмийн даатгалын санд шилжүүлжээ.

Нийгмийн даатгалын санд 2020 онд 8.2 тэрбум төгрөгийн сангийн орлого төвлөрүүлсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 0.5 тэрбум төгрөгөөр буурсан.

Ажил олгогч, даатгуулагчаас төлсөн шимтгэлийн орлогыг дараах байдлаар нийгмийн даатгалын сангуудад хуваарилсан байна. Үүнд

- Тэтгэврийн даатгалын санд 73.2 % буюу 5820.6 сая төгрөг
- Тэтгэмжийн даатгалын санд 7,1 % буюу 566.2 сая төгрөг;
- ҮОМШӨ-ний даатгалын санд 3.9 % буюу 316.9 сая төгрөг;
- Ажилгүйдлийн даатгалын санд 1.4 % буюу 110.5 сая төгрөг;
- Эрүүл мэндийн даатгалын санд 14.4 % буюу 1140.8 сая төгрөг

2020 оны нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, тусламж, үйлчилгээний зардалд нийт 25.7 тэрбум төгрөг зарцуулжээ. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад сангийн зардал 3.6 тэрбум төгрөгөөр өссөн байна.

Тухайн сард тэтгэврийн даатгалын санд 5391 сая төгрөгийн орлогыг төвлөрүүлж, улсын төсвөөс 25750 сая төгрөгийг тэтгэврийн даатгалын санд хүлээн авсан. Тус сангаас өндөр насны, тахир дутуугийн, тэжээгчээ алдсаны, цэргийн тэтгэвэр авагч 15.2 мянган иргэдийн тэтгэвэрт 25.7 тэрбум төгрөг зарцуулжээ. Нийт 75.8 хувь буюу 19.5 тэрбум төгрөгийг өндөр насны тэтгэвэр авагч 11.1 мянган иргэнд зарцуулсан байна.

Гэр бүл, хүүхэд, залуучууд

Хүүхдийн чөлөөт цагийг үр бүтээлтэй өнгөрүүлэх, тэдний дуу хоолойг сонсож, гэр бүлдээ хүсэж буй зүйлийг мэдэх, гэр бүлийн орчинд хүүхдийг хөгжих боломжийг нэмэгдүүлэх зорилгоор аймгийн Цагдаагийн газар, Мобиком компанийн салбартай хамтран “Би гэр бүлдээ үүнийг л хүсдэг” цахим уралдааныг “Гар зураг”, “Мессэж”, “Зохион бичлэг”, “Эссэ бичлэг” гэсэн 4 төрлөөр зохион байгууллаа. Уралдаанд 10 сумын ерөнхий боловсролын сургуулийн 1-12 дугаар ангийн 160 гаруй хүүхэд багачууд оролцсон байна.

Тав. Хөдөө аж ахуйн бодлогын хүрээнд Мал аж ахуй

Архангай аймгийн хэмжээнд энэ онд 2.359.4 мянган толгой хээлтэгч мал төллөхөөс 1774885 мянган толгой мал төллөөд байна. Үүнд: Хээл авсан хээлтэгчээс Ингэ 222 буюу 78.4 хувь, Гүү 90792 буюу 94 хувь, Үнээ 190391 буюу 100 хувь, Эм хонь 1155066 буюу 97 хувь, Эм ямаа 491242 буюу 82.5 хувь төллөж, мал төллөлт 81.7 хувьтай, 1637271 мянган толгой төл 84.9 хувьтай бойжиж байна.

Том малын зүй бус хорогдлоор 324505 мянган толгой мал, нийт малын 5.3 хувь нь хорогдсон байна. Үүнээс хээлтүүлэгч 1098, өвчнөөр 6167 мянган толгой мал хорогдсон байна.

Аймгийн хэмжээнд Ихтамир, Тариат, Чулуут, Өндөр-Улаан, Хотонт, Эрдэнэмандал сумдын 11000 толгой малд үзлэг ангилалт хийж цөм сүрэг бүрдүүлэн баталгаажуулах ажлыг дараах мал үржүүлэг технологийн ажил үйлчилгээний нэгжүүдээр гүйцэтгүүлэхээр гэрээ байгуулсан. 6-р сарын 03-ны өдрийн байдлаар Чулуут, Тариат, Өндөр-Улаан, Ихтамир сумын 2300 толгой сарлаг, Ихтамир сумын 1500 толгой хонинд үзлэг ангилалтыг хийсэн.

“Хонь, тэмээний ноос бэлтгэж, үндэсний үйлдвэрт тушаасан малчин, мал бүхий этгээдэд мөнгөн урамшуулал олгох журам батлах тухай” Засгийн газрын 2019 оны 343 дугаар тогтоолын дагуу аймгийн хэмжээнд 6.1 мянган малчин өрхийн 1718.2 тн ноосонд 2577.3 сая төгрөгийн урамшуулал, мөн 10.2 мянган малчин өрхийн бодын 46.2 мянган ширхэг шир, богийн 240.2 мянган ширхэг арьсанд 1.4 тэрбум төгрөгийг олгох ажлыг зохион байгуулж байна.

Орон нутгийн хөгжлийн сан болон “Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил” төслийн санхүүжилтээр 17 суманд инженерийн хийцтэй гүн өрмийн 44 худгийг гаргах ажлын гүйцэтгэгчээр “Топ дринлинг” ХХК, “Усны барилга” ХХК, “БИММ” ХХК, “Энержи эмпайр” ХХК, “Би Ди Икс инженеринг” ХХК-иуд шалгарч ажлаа эхэлсэн бөгөөд ажлын гүйцэтгэл 60 хувьтай байна.

“Ногоон алт, малын эрүүл мэнд” төслийн хүрээнд сумдын “Бэлчээр ашиглагчдын холбоо” ТББ, мал үржүүлэг технологийн нэгжтэй хамтран Ихтамир суманд 660 хурга, Өндөр-Улаан суманд 150 хурга, Чулуут суманд 50 хурга нийт 860 хургыг төөнөх аргаар засч хөнгөлөн эзэмгжүүлэх ажлыг зохион байгуулсан. Төөнөх аргаар засч хөнгөлөх нь хурга, өсвөр насны үхрийг эрчимтэй өсгөх, махан ашиг шимийг нэмэгдүүлэх давуу талтай юм.

Үлийн цагаан оготной тэмцэх ажлыг Хангай, Цахир, Цэцэрлэг, Өлзийт, Өгийнуур сумдын 25000 га бэлчээрт микробиологийн аргаар, Батцэнгэл, Хайрхан, Эрдэнэмандал, Төвшрүүлэх, Хотонт, Чулуут, Хашаат сумдын 70000 га талбай бэлчээрт байгаль орчинд халгүй энгийн механик, биологийн аргаар, нийт 95000 га бэлчээрт зохион байгуулж дээрхи сумдын 37 багийн 1100 малчид, иргэд, төрийн албан хаагчид, 133 автомашин, 177 мотоцикль техник хэрэгсэл ашиглан оролцож, хяналтын тооллого хийхэд 229 хяналтын цэг тогтоон нэг га талбайд дунджаар 608 мэрэгч байсныг 171 болгон цөөрүүлэн үлийн цагаан оготной тэмцсэн ажлын техникийн үр дүн 80 хувьтай байна.

Үлийн цагаан оготной тэмцэх ажлыг зохион байгуулахад орон нутгаас 13.9 сая төгрөгийг зарцуулсан, мөн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн нийтийг хамарсан ажлын хүрээнд 172 ажилгүй иргэдийг татан оролцуулж 15.7 сая төгрөг зарцуулан нэмж 10000 га бэлчээрт тэмцэх ажлыг зохион байгуулсан.

Газар тариалан

Энэ хаврын тариалалтад зориулж шар луувангийн үр 50 кг, хүрэн манжингийн үр 5 кг, шар манжингийн үр 10 кг, урт сонгинын үр 3 кг, бөөрөнхий сонгинын үр 1 кг, төл сонгинын үр 20 кг, сармисны үр 5 кг, чинжүүний үр 0,25 кг, улаан лоолийн үр 2 уут, өргөст хэмхийн үр 5 уут бүхий 3 сая төгрөгийн хүнсний ногооны үрийг Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн яамнаас үнэгүй олгосныг аймгийн 19 суманд хуваарилж Хөдөө аж ахуйн тасагт хүлээлгэн өглөө.

“Өрх бүр үйлдвэрлэгч” дэд хөтөлбөрийн хүрээнд өвөл, зуны хүлэмжийн цогцолбор аж ахуй”-н 2020 оны үйл ажиллагаа эхэлж тариалалтаа хийж байна. Энэ цогцолборт одоогийн байдлаар 6х40 м-ийн харьцаатай зуны 6 хүлэмжид үйл ажиллагаа явуулж байна. Шинээр нэмж 10х40 м-ийн харьцаатай өвлийн 1 хүлэмж баригдаж байна Уг цогцолбор аж ахуйд 18 хүн ажиллаж улаан лооль, өргөст хэмх, чинжүү, бууцай, жууцай, кимчиний болон брокли байцаа зэрэг 13 нэр төрөл бүрийн хүнсний ногоо тариалж байна.

Тариалангийн гол сум болох Хотонт, Төвшрүүлэх, Өгийнуур зэрэг сумдын тариалангийн талбайгаар явж, соёлолт тодорхойлсон бөгөөд аймгийн хэмжээгээр нийт талбайн 7.3% нь онц, 25.1% нь сайн, 56.4% нь дунд, 11.2% нь муу соёлолттой байна.

“Атар-4” тариалангийн тогтвортой хөгжлийн аяныг хэрэгжүүлэх төлөвлөгөөг боловсруулж аймгийн Засаг даргын 2020 оны 6-р сарын 04-ний өдрийн А/368 дугаар захирамжаар батлуулан ажиллаж байна.

Аймгийн хэмжээнд 7570 га талбайд улаанбуудай, 213 га талбайд төмс, 114 га талбайд хүнсний ногоо, 1283 га талбайд ногоон тэжээл, 131 га талбайд тосны ургамал тариалж, хаврын тариалалт 73 хувьтай явагдаж байна.

Жижиг дунд үйлдвэр

Аймгийн Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих дэд санд 2020 оны 4-р сарын 20-ны өдрөөс 5-р сарын 19-ний өдрийн 17.30 цаг хүртэл 32 аж ахуйн нэгжийн 3.972.661.800 төгрөгийн санхүүжилт хүссэн төслийг битүүмжлэн хүлээн авч цахим бүртгэлийн системд бүртгэн ажиллалаа. Одоогоор төслийн баримт бичгийн бүрдлийг шалгах шатанд явж байна.

ХХААХҮЯ-аас зохион байгуулж байгаа Хоршооны хөгжлийг үнэлэх ажлын удирдамжийн дагуу хоршооны үнэлгээг 19 сумдаас авч нэгтгэж байна.

Зургаа. Байгаль орчин, үйлдвэрлэл үйлчилгээ, дэд бүтцийн салбарын бодлогын хүрээнд

Байгаль орчин, аялал жуулчлал

Хот тохижилт, нийтийн ахуйн үйлчилгээний газраас 6-р сарын 12-ноос 18-ны өдрүүдэд аймгийн төвийн 12-н уулзвараас 999 төвийн уулзвар, Нисэхийн тойргоос ТОСК-н гарц хүртэлх замын хоёр талын 87 ш улиас, 424 ш хар модыг хортон шавьнаас хамгаалж шохойдон ногоон байгууламжийн арчилгааг хийсэн байна.

Архангай аймагт ойжуулалтын ажлын тусгай зөвшөөрөлтэй аж ахуй нэгжүүдийн мод үржүүлгийн талбай болон тарьц суулгацын нөөцийн талаар 6-р сарын 4-нөөс 7-ны өдрийг хүртэл хяналт шалгалт хийсэн.

2019 оны намрын судалгаа, 2020 оны хаврын судалгааг үндэслэн орон нутгийн төсвийн хөрөнгөөр Цэнхэр сумын Мандалын бургас, Цэцэрлэгийн голын бургас, Төвшрүүлэх сумын Гурвын даваа, Ар хүйтэн, Бор бургастын рашааны хойд ар, Бурхант гэх газруудад ойн хортонтой тэмцэх ажил хийгдэж, байнгын хяналт шалгалт зохион байгуулж ажилласан.

Голын эрэг дээр ойжуулалт хийж богино хугацаанд сэргэн ургалт бий болгож, голын урсацыг нэмэгдүүлэх зорилгоор Булган сумын Тусгалт, Тамир, Баянбулаг багийн орон нутгийн тусгай хамгаалалттай газрын 11-н нөхөрлөлийн 50 гаруй гишүүд санаачилга гаргаж Лондонгийн амьтан судлалын нийгэмлэг, аймгийн БОАЖГ, Сум дундын ойн анги, Булган сумын ЗДТГ-тай хамтран Тамирын голын эрэг дагуу улиасны мөчрөөр ойжуулалт хийх ажлыг өөрсдийн хөрөнгөөр хийж гүйцэтгэж байна.

Хүнс, үйлдвэрлэл үйлчилгээ

“Шинэ коронавирсийн болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх тухай” аймгийн Засаг даргын 2020 оны 02 дугаар албан даалгаварт тусгагдсан хүн амыг хүнсний хомсдол үүсэх эрсдэлээс урьдчилан сэргийлж, нөөцийн судалгааг гаргаж, аймгийн Онцгой комиссыг мэдээллээр хангах чиглэл өгөгдсөн тул Эрдэнэбулган сум болон бусад сумдад үйл ажиллагаа явуулж буй томоохон худалдааны төв болох “Гост Трейд” ХХК, “Тансаг Трейд” ХХК, “Тансаг Оюу” ХХК, “Ижий Трейд” ХХК, “Жи Эи Би” ХХК, “Хадат Хужирт” ХХК, “Бүрэн Ар” ХХК-иудад хүнсний нөөцийн судалгааг 7 хоног бүр ирүүлэх тоот хүргүүлж, судалгааг нэгтгэн, ХХААХҮЯ-ны ХҮХБЗГ болон аймгийн Онцгой байдлын газарт хүргүүлж байна. Сүүлийн 7 хоногийн судалгаагаар мах 23.5 тн буюу 2 хоног, гурил 251.7 тн буюу 33 хоног, гоймон 24 тн буюу 2 хоног, будаа 71.1 тн буюу 19 хоног, сахар 50.4 тн буюу 20 хоног, ургамлын тос 21 тн буюу 12 хоног, давс 22.2 тн буюу 56 хоног, ундны ус 53.4 мян.л буюу 1 хоног, хуурай сүү 4.2 тн буюу 3 хоног, төмс 34.8 тн буюу 13 хоног, хүнсний ногоо 16 тн буюу 2 хоног, өндөг 1.06 тн буюу 1 хоногийн нөөцтэй байна.

Барилга, дэд бүтэц

Архангай аймагт 2020 îä уёñîí ò°ñвийн хөрөнгөөр 79 тэрбум 798.9 сая төгрөгийн өртөг бүхий 41 төсөл арга хэмжээ, ОНХС-ийн хөрөнгөөр 955.0 сая төгрөгийн өртөг бүхий 8 багц төсөл арга хэмжээ, БСШУС-ын сайдын багцын 423.6 сая төгрөгийн өртөг бүхий 6 төсөл арга хэмжээ, нийт 81 тэрбум 177.5 сая төгрөгийн өртөг бүхий 55 төсөл арга хэмжээний захиалагчийн хяналтыг хэрэгжүүлэхээр төлөвлөөд ажиллаж байна.

Үүнээс эхний хагас жилийн байдлаар цаг үеийн байдалтай холбогдон уёñîí ò°ñвийн хөрөнгөөр 43 тэрбум 822.2 сая төгрөгийн өртөг бүхий 31 төсөл арга хэмжээ, ОНХС-ийн хөрөнгөөр 495.0 сая төгрөгийн өртөг бүхий 8 төсөл арга хэмжээ, БСШУС-ын сайдын багцын 423,6 сая төгрөгийн өртөг бүхий 6 төсөл арга хэмжээ, нийт 44 тэрбум 740.8 сая төгрөгийн өртөг бүхий 45 төсөл арга хэмжээний гүйцэтгэгч шалгарч, барилгын ажил эхлээд байна.

2020 онд авто замын сангийн нийт 435.0 сая төгрөгийн хөрөнгөөр 9 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээс эхний хагас жилийн байдлаар 7 төсөл арга хэмжээний гүйцэтгэгч шалгарч, ажил эхэлсэн, 2 төсөл арга хэмжээг 9-р сараас эхлүүлэхээр төлөвлөсөн байна.